

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/024/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас:51-261628 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261885 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/1209
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудад дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Тайлант оны төсвийг байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан батлуулаагүй, 6,374.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 1 аж ахуй нэгжийн протезын үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон 1,552.2 сая төгрөгийн зээлийн авлагын эргэн төлөлтөөс 734.9 сая төгрөг нь төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс төсвийн захирагчид хуваарилсан 9.0 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 230.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 22.7 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 780.0 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 1,665.4 сая төгрөг, нийт 2,708.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлснээс 2,170.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 573.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдийг нийгмийн бүх үйлчилгээнд тэгш хамруулах зарчимд нийцүүлэн хөгжлийн бэрхшээл, сэргээн засах чиглэлээр мэргэшсэн, хүртээмжтэй нийгмийг дэмжих зорилгоор Ховд, Хөвсгөл, Дархан-Уул, Архангай, Дорнод, Дундговь аймгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төвийг шинээр байгуулсан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-ны санхүүгийн дэмжлэгт 15 төрийн бус байгууллагад 300.0 сая төгрөгийг 50 хувийн эргэн төлөх нөхцөлтэйгөөр, 18 аж ахуй нэгж байгууллагад 700.0 сая төгрөгийг 100 хувийн эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгож, нийт 33 байгууллагад 1,000.0 сая төгрөгийн санхүүгийн зээл олгож, 100 ажлын байрыг шинээр бий болгосон байна.

Бусад асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяа байгууллагууд нь 2024 онд гадны орны эмнэлгүүд, судалгааны төвүүдтэй хамтран эмнэлгийн эмч сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах, дадлага хийлгэх, сургах “Гэрэлт цамхаг” төслийг эхлүүлсэн байна. Төслийн хүрээнд Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, багш, ажилтнуудыг өндөр хөгжилтэй улс орнуудад туршлага судлах шинэ техник технологийн нэвтрүүлэх, мэргэшүүлэх дадлагажуулах зорилгоор Тайвань улсын эмнэлэгтэй хамтран ажиллаж, 4 мэргэжилтнийг мэргэшүүлэн сургаж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГ



Я.САМБУУНЯМ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		6,514,992.2	6,059,123.1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	3.9	-
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	3,349,552.5	2,352,489.1
УРЬДЧИЛГАА	7а, 7б	41,339.0	-
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	3,124,096.7	3,706,634.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		25,294,663.4	26,112,423.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	25,294,663.4	26,112,423.6
Биет хөрөнгө		23,967,310.7	24,606,113.8
Биет бус хөрөнгө	13	1,327,352.7	1,506,309.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		31,809,655.6	32,171,546.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР		61,139.4	24,805.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	61,139.4	24,805.8
Өглөг	17а, 17б	30,799.6	6,015.8
Урьдчилж орсон орлого	18а, 18б	30,339.8	18,790.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		31,748,516.1	32,146,740.9
Засгийн газрын хувь оролцоо		31,748,516.1	32,146,740.9
Засгийн газрын оруулсан капитал		9,639,448.7	9,639,448.7
Хуримтлагдсан үр дүн		16,620,526.2	17,018,751.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		5,488,541.0	5,488,541.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		31,809,655.6	32,171,546.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		24,853,952.3	29,594,600.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	8,381,547.4	4,285,608.0
Нийтлэг татварын бус орлого		8,381,547.4	4,285,608.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		16,472,404.9	25,308,992.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	16,907,482.6	29,155,549.3
УРСГАЛ ЗАРДАЛ		16,907,482.6	29,155,549.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		13,540,524.9	22,431,287.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		7,710,757.7	13,325,361.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		959,929.2	1,723,270.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		679,487.5	824,933.8
Хангамж, бараа материалын зардал		393,563.5	520,625.8
Нормативд зардал		1,000,679.0	1,248,451.1
Эд хогшил, урсгал засварын зардал		38,715.1	471,623.4

Томилолт, зочны зардал		0	33,891.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		376,175.7	695,718.4
Бараа үйлчилгээний бусад зардал		2,381,216.9	3,587,411.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,366,957.7	6,724,261.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		7,946,469.6	439,051.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0	102.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,586.4	59,901.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		7,944,883.2	379,251.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	15,803,665.5	27,234,859.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	256,599.6	469,244.4
Нийтлэг татварын бус орлого	256,599.6	469,244.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,547,065.8	26,765,614.7
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,632,212.1	26,857,221.5
УРСГАЛ ЗАРДАЛ	15,632,212.1	26,857,221.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,875,843.8	19,038,991.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,282,771.2	12,806,484.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	948,499.2	1,708,034.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	675,743.2	824,933.8
Хангамж, бараа материалын зардал	211,902.8	381,425.3
Нормативт зардал	1,134,914.7	1,418,542.1
Эд хогшил, урсгал засварын зардал	113,231.0	633,621.1
Томилолт, зочны зардал	-	37,042.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	380,128.6	719,454.4
Бараа үйлчилгээний бусад зардал	128,652.8	509,453.5
ТАТААС	637,345.7	716,994.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,119,022.5	7,101,235.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	171,453.4	377,637.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	171,453.4	377,641.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	171,453.4	377,641.6
Дотоод эх үүсвэрээр	171,453.4	377,641.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(171,453.4)	(377,641.6)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	(3.9)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3.9	3.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3.9	-

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,597,272.2	-	23,597,272.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	207,910.5	-	207,910.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,805,182.8	-	23,805,182.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,550.0)	-	(1,550.0)
Тайлант үеийн үр дүн	7,944,883.2	-	7,944,883.2
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	31,748,516.1	-	31,748,516.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	18,972.9	-	18,972.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	31,767,489.0	-	31,767,489.0
Тайлант үеийн үр дүн	379,251.9	-	379,251.9
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,146,740.9	-	32,146,740.9

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,009,751,300.00	18,161,258,488.20	5,848,492,811.80	75.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,009,751,300.00	18,161,258,488.20	5,848,492,811.80	75.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,005,843,000.00	17,256,174,667.41	5,749,668,332.59	75.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,129,510,000.00	12,050,559,128.72	3,078,950,871.28	79.6
210101	Үндсэн цалин	7,601,353,700.00	6,301,618,097.64	1,299,735,602.36	82.9
210102	Нэмэгдэл	4,763,532,500.00	3,514,960,768.58	1,248,571,731.42	73.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,411,299,500.00	1,156,310,143.98	254,989,356.02	81.9
210104	Урамшуулал	1,328,267,600.00	1,013,447,486.50	314,820,113.50	76.3
210105	Гэрээт ажлын хөлс	25,056,700.00	64,222,632.02	(39,165,932.02)	256.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,919,886,400.00	1,618,186,780.16	301,699,619.84	84.2
210201	Тэтгэврийн даатгал	1,330,867,400.00	1,146,721,536.46	184,145,863.54	86.1
210202	Тэтгэмжийн даатгал	147,254,800.00	124,634,577.12	22,620,222.88	84.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	73,626,900.00	64,021,191.38	9,605,708.62	86.9
210204	Ажилгүйдлийн даатгал	73,627,600.00	52,808,573.90	20,819,026.10	71.7
210205	Эрүүл мэндийн даатгал	294,509,700.00	230,000,901.30	64,508,798.70	78.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,188,569,800.00	824,933,888.10	363,635,911.90	69.4
210301	Гэрэл, цахилгаан	406,129,900.00	282,659,995.18	123,469,904.82	69.6

210302	Түлш, халаалт	540,817,200.00	406,239,171.78	134,578,028.22	75.1
210303	Цэвэр, бохир ус	241,622,700.00	136,034,721.14	105,587,978.86	56.3
2104	Хангамж, бараа материалын зардал	359,846,500.00	297,106,215.72	62,740,284.28	82.5
210401	Бичиг хэрэг	66,160,200.00	57,851,676.65	8,308,523.35	87.4
210402	Тээвэр, шатахуун	55,314,400.00	38,703,996.00	16,610,404.00	69.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,363,500.00	53,897,677.87	15,465,822.13	77.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	56,989,100.00	38,652,041.00	18,337,059.00	67.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	112,019,300.00	108,000,824.20	4,018,475.80	96.4
2105	Нормативт зардал	1,811,590,800.00	1,336,087,923.62	475,502,876.38	73.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	989,568,900.00	814,393,623.62	175,175,276.38	82.3
210502	Хоол, хүнс	678,973,000.00	385,349,350.00	293,623,650.00	56.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	143,048,900.00	136,344,950.00	6,703,950.00	95.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	415,448,100.00	356,226,844.00	59,221,256.00	85.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	199,486,500.00	183,481,045.00	16,005,455.00	91.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	39,989,800.00	26,593,496.00	13,396,304.00	66.5
210604	Урсгал засвар	175,971,800.00	146,152,303.00	29,819,497.00	83.0
2107	Томилолт, зочны зардал	4,708,800.00	1,700,000.00	3,008,800.00	36.1
210702	Дотоод албан томилолт	4,708,800.00	1,700,000.00	3,008,800.00	36.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,023,108,300.00	634,241,770.20	1,388,866,529.80	31.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,876,810,800.00	549,539,416.96	1,327,271,383.04	29.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	49,276,400.00	27,408,000.00	21,868,400.00	55.6
210803	Даатгалын үйлчилгээ	5,689,300.00	1,837,341.00	3,851,959.00	32.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,307,100.00	437,000.00	870,100.00	33.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	474,700.00	197,400.00	277,300.00	41.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,846,600.00	19,268,230.24	12,578,369.76	60.5
210807	Газрын төлбөр	8,524,200.00	4,104,482.00	4,419,718.00	48.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200	0	200.00	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	49,179,000.00	31,449,900.00	17,729,100.00	63.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,174,300.00	137,132,116.89	16,042,183.11	89.5

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,460,000.00	36,265,304.50	1,194,695.50	96.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	115,714,300.00	100,866,812.39	14,847,487.61	87.1
212	ТАТААС	717,550,000.00	717,544,499.96	5,500.04	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	717,550,000.00	717,544,499.96	5,500.04	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	286,358,300.00	187,539,320.83	98,818,979.17	65.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	286,358,300.00	187,539,320.83	98,818,979.17	65.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	257,853,400.00	164,337,520.83	93,515,879.17	63.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,504,900.00	23,201,800.00	5,303,100.00	81.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,009,751,300.00	18,161,254,588.20	5,848,496,711.80	75.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,197,632,200.00	14,725,196,211.20	6,472,435,988.80	69.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	21,197,632,200.00	14,725,196,211.20	6,472,435,988.80	69.4
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,427,119,100.00	2,966,475,889.00	(539,356,789.00)	122.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	385,000,000.00	469,582,488.00	(84,582,488.00)	121.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	340,000,000.00	387,066,280.00	(47,066,280.00)	113.8
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,000,000.00	82,516,208.00	(37,516,208.00)	183.3
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	10	10	-	100.0
610001	Төсвийн байгууллага	10	10	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	514	475	39	92.4
620001	Удирдах ажилтан	14	14	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	376	345	31	91.7
620003	Үйлчлэх ажилтан	121	113	8	93.3
620004	Гэрээт ажилтан	3	3	-	100.0

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,700,090,588.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,700,090,588.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,161,271,940.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		755,925,150.00
210101	Үндсэн цалин		5,266,800.00
210102	Нэмэгдэл		750,658,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		89,847,584.54
210201	Тэтгэврийн даатгал		59,847,584.54
210202	Тэтгэмжийн даатгал		7,500,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		6,000,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1,500,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал		15,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		87,366,439.35
210401	Бичиг хэрэг		23,799,903.35
210402	Тээвэр, шатахуун		2,640,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		60,926,536.00
2105	Нормативт зардал		140,187,235.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,560,240.00
210502	Хоол, хүнс		137,726,995.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		590,291,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		152,364,350.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,000,000.00
210604	Урсгал засвар		436,927,570.00
2107	Томилолт, зочны зардал		35,342,780.00
210702	Дотоод албан томилолт		35,342,780.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		89,572,720.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		89,309,016.65
210807	Газрын төлбөр		263,704.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		372,738,111.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,967,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		369,771,111.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		538,818,647.46
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,100,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		537,718,647.46
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		537,718,647.46
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,700,090,588.31
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,700,090,588.31
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		230,877,050.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,010,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		22,747,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		772,080,358.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		1,665,376,180.31
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төвлөрүүлэн захирагч болон харьяа 10 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, аудитад хамрагдсан 10 байгууллагад дүгнэлт гаргасан байна.

Аудитаар 5 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 5 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 1,185.8 сая төгрөгийн 26 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 1,933.4 сая төгрөгийн зөрчил илэрч, 8.5 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 629.5 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 945.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 14 зөвлөмж, 349.9 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,933.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,693.4 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 982.4 сая төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийлгэсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 1,933.4 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй, батлагдсан төсөвтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт 1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагын төсвийг тухайн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөж, батлуулаагүйгээс нийт 6,374.8 сая төгрөг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн. Тухайлбал:

- ХБХСЗТ- 7,603.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,652.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн;
- 2. ХБХХЕГ /аппарат/- 3,407.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,801.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн;
- 3. Архангай аймгийн ХБХХГ-1,062.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 858.6 сая төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагуудын төсвийн төслийг бодитой хянаж, төсвийг үйл ажиллагаа, байгууллагын онцлогтой уялдуулан батлуулах.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал:

Илрүүлэлт 4. Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа 10 байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 71 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 1,185.8 сая төгрөгийн 26 алдаа, 1,933.4 сая төгрөгийн 31 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 1,733.0 сая төгрөгийн 14 зөрчил

илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын үр дүнтэй хэрэгжүүлэн, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, зөрчлийг 20 хувиар багасгах арга хэмжээг авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Аудитаар нийт 2,168.2 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 2,168.2 сая төгрөгийн алдааг залруулга хийлгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	3=5+7	4=6+8	5	6	7	8	9	10	11	12	13=11	14=12
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар-ТТЗ	4	982,360.8	-	-	4	982,360.8	4	982,360.8	-	-	-	-
	Дүн	4	982,360.8	-	-	4	982,360.8	4	982,360.8	0	0	0	0
Харьяа байгууллагууд-ТШЗ													
1	Дорнод ХБХХТ	2	5,148.4	1	4,774.0	1	374.4	2	5,148.4	-	-	-	-
2	Дундговь ХБХХТ	2	299.5	2	299.5	-	-	2	299.5	-	-	-	-
3	Дархан-Уул ХБХХТ	3	268,848.4	1	115,837.4	2	153,011.0	3	268,848.4	-	-	-	-
4	Ховд ХБХХТ	3	168,832.0	1	151,492.6	2	17,339.4	3	168,832.0	-	-	-	-
5	СЗСҮТ	1	2,353.4			1	2,353.4	1	2,353.4	-	-	-	-
6	ХБХХЕГазар	13	302,538.1	10	92,563.7	3	209,974.4	13	302,538.1	-	-	-	-
7	ХБХСЗХТөв	2	437,837.5			2	437,837.5	2	437,837.5	-	-	-	-
	ДҮН	26	1,185,857.3	15	364,967.2	11	820,890.1	26	1,185,857.3	-	-	-	-
	НИЙТ ДҮН	30	2,168,218.1	15	364,967.2	15	1,803,250.9	30	2,168,218.1	-	-	-	-

4.2. Аудитаар нийт 1,933.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 8.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 629.5 сая төгрөгийн албан шаардлага, 349.9 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 945.5 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо
1	ХБХХЕГ-ТТЗ	2	-					2	-						
2	Архангай ХБХХТ-ТШЗ	1	9,605.0			1	9,605.0								
3	Дорнод ХБХХТ-ТШЗ	2	-					2							
4	Дархан ХБХХТ-ТШЗ	2	24,497.7	1	4,006.10	1	20,491.6								
5	Ховд ХБХХТ-ТШЗ	2	28,009.5	1	1,271.5			1	26,738.0						
6	Хөвсгөл ХБХХТ-ТШЗ	1	861.9	1	861.9										
7	ХХХСХТөв-ТШЗ	3	117,792.5			1	64,243.6	2	53,548.9						
8	ХБХСЗХТөв-ТШЗ	13	974,845.2	1	980.0	3	150,146.2	9	823,719.0						
9	СЗСҮТөв-ТШЗ	3	41,475.4	0	-	1	-	2	41,475.4						
10	ХБХХЕГазар-ТШЗ	4	736,299.4	2	1,399.4	1	385,000.0	0	-	1	2	349,900.0			
	НИЙТ ДҮН	33	1,933,386.6	6	8,518.9	8	629,486.4	18	945,481.3	1	2	349,900.0	-	-	

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1,733.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 117.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1,616.0 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

	Аймгийн нэрс	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХБХХЕГ-ТТЗ	1	-			1	-							
2	Дархан ХБХХТ	1	5,462.4			-		1	5,462.4					
3	Дундговь ХБХХТ	1	16,185.0			1	16,185.0							
4	Ховд ХБХХТ	1	-					1	-					
5	ХөвсгөлХБХХТ	1	-					1	-					
6	ХХХСХТөв	4	1,610,519.7					4	1,610,519.7					
7	ХБХСЗХТөв	1	-			1								
8	ХБХХЕГазар	4	100,846.0			4	100,846.0							
НИЙТ ДҮН		15	1,733,013.1	-	-	7	117,031.0	8	1,615,982.1	-	-	-	-	-